



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 438

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга
хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 225.6 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2016 он, 2017 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын захирал Р.Будад дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1.Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллах;

2.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг худалдан авах ажиллагаанд мөрдөж ажиллах;

2.3.Санхүүгийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.2-д заасан “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” зарчим, Засгийн газрын 2018 оны “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай” 8 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлэх;

2.4.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалтыг мөрдөж, засваргүй, үнэн зөв хөтлөгдөж, баримтын бүрдлийг хангасан санхүүгийн баримтаар зарлагын гүйлгээ хийж, санхүүгийн тайланд тусгаж байх;

2.5.Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн
538 дугаар тогтоолын хавсралт

Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга хэмжээний жагсаалт

Д/Д	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах ажилтан	Дүн (мян.төгрөг)	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Сонгон шалгаруулалт явуулалгүй хийсэн худалдан авалт	Захирал - Р.Буд Ерөнхий ня-бо - Б.Дуламханд	119,619.50	Төрийн болон орон нут-гийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худал-дан авах тухай хуулийг мөрдөж ажиллах
2	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө-нөөс гадуур хийсэн худалдан авсан	Захирал - Р.Буд Ерөнхий ня-бо - Б.Дуламханд	25,535.6	
3	Дотоод албан томилолтын журам зөрчсөн	Захирал - Р.Буд Ерөнхий ня-бо - Б.Дуламханд	5,876.2	Албан томилолтын журмыг мөрдөж ажиллах
	Гадаад албан томилолт. Гадны байгууллагын зардал хариуцсан		13,009.27	
4	Нягтлан бодох бүтгэлийн хууль, Төсвийн хууль, Мөнгөн кассын ўйл ажиллагааны журам зөрчин бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн	Захирал - Р.Буд Ерөнхий ня-бо - Б.Дуламханд	26,771.14	Нягтлан бодох бүрт-гэлийн хууль, Төсвийн хууль, Мөнгөн кассын ўйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах
5	Төсвийн хууль зөрчин үргүй зардал гаргасан.	Захирал - Р.Буд Ерөнхий ня-бо - Б.Дуламханд	2,944.5	Төсвийн хууль, хөлбогдох журмыг мөрдөж ажиллах
6	Хууль зөрчин төрийн өмчийг бусад байгууллагад зээлээр ашиглуулсан	Захирал - Р.Буд Ерөнхий ня-бо - Б.Дуламханд	31,850.00	
	Дүн		225,606.21	